



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Говь-Алтай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1. Зам, тээврийн хөгжлийн яамны санал, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/4450 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Говь-Алтай АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар Батчулууны Алтанхуягийг томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

1.2. “Говь-Алтай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Алтанхуягтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хууль тогтоомжийн дагуу байгуулж ажиллах.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ